



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: “Монгол улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн аймгуудын нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилт” нийцлийн аудит

ҮАГ- НАГ/2015/01-НА-ХөААГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн нийцлийн аудитын тайлан



Шаардлагатай урвалж, оношлуур авахад батлагдсан төсөв хүрэлцэхгүй байна.

Хөвсгөл аймаг Мөрөн сум

2015 оны 02 дугаар сар

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Хөвсгөл аймгийн Аудитын газар	БҮЛЭГ-1. Барилгын их засварын худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулсан байна.	5
Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл	1.1 Худалдан авах ажиллагааны журмыг оновчтой сонгосон байна.	5
Аудитын менежер Г.Эрдэнэчимэг	БҮЛЭГ-2. Зарим тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна.	5
Шинжээч Б.Сандуйжав	2.1 Гэрээний нөхцлийг бүрэн тусгасан байна.	5
2015 оны 02 дугаар сар	2.2 Барилгын их засварын зарим ажлыг зураг, төсөвт тусгагдсаны дагуу хийгээгүй байна.	5
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утас, 70383793 дугаарын факсаар харилцана уу?	2.3 Оношлогооны төвийн тоног төхөөрөмжүүдийг бүрэн ашиглаагүй байна.	7
ХАЯГ: (Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын А байр)	Дүгнэлт.....	15
	Зөвлөмж.....	16
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	17
	Хавсралт	18
	Зөрчлийн жагсаалт.....	26

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ХөААГ	Хөвсгөл аймгийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
БНСУ	Бүгд найрамдах солонгос улс
ЭНЭШТ	Эх, нялхсын эрдэм шинжилгээний төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НХХ	Нийгмийн хөгжлийн хэлтэс
ЭМГ	Эрүүл мэндийн газар
НЭ	Нэгдсэн эмнэлэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Хөвсгөл аймагт нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа оновчтой эсэх.
- Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн ЗДТГ-ын НХХ, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн нэгдсэн оношлогооны төвтэй холбогдох мэдээ, тайлан, судалгаа, тайлбар хамрагдлаа.

Аудитын арга зүй

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан байгууллагаас тайлбар, асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам, шийдвэр

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын харьяа Хөвсгөл аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдан, аудитын менежер Г.Эрдэнэчимэг аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, шинжээч Б.Сандуйжав гүйцэтгэв.

Бүлэг 1: Барилгын их засварын худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулсан байна.

1.1 Худалдан авах ажиллагааны журмыг оновчтой сонгосон байна.

Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагаа нь орон нутагт хийгдээгүй байна. Иймд: Тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагаа оновчтой болсон эсэх талаар дүгнэх боломжгүй байна.

Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээний барилгын ажлын тухайд: Тус аймаг нь тоног төхөөрөмжийг суурилуулахтай холбогдуулан Нэгдсэн эмнэлэгт барилгын их засварын ажил хийгдсэн байна. Уг их засварын ажлын төсөвт өртөг нь 180,0 сая төгрөг бөгөөд худалдан авах ажиллагааг орон нутагт зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны үр дүнг шалгахад:

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасны дагуу 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр нээлттэй тендер зарлаж, урилгыг “Үнэн” сонин болон вэб хуудсанд нийтэлсэн байна. Уг худалдан авах ажиллагаанд барилга угсралтын 5 компани материал ирүүлснээс “Хөвсгөл жугнай” ХХК-г сонгон шалгаруулсан байна.

Бүлэг 2: Зарим тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байна.

2.1 Гэрээний нөхцлийг бүрэн тусгасан байна.

Оношлогооны төвийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ нь орон нутагт байхгүй тул гэрээний нөхцлийг хэрхэн тусгасан болон гэрээний үүргээ бүрэн хангасан эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хийсэн засварын тухайд: Захиалагч байгууллага¹ гүйцэтгэгчээр шалгарсан “Хөвсгөл жугнай” ХХК-тай 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр барилгын засварын ажлыг 2013 оны 12 дугаар сарын 21-ний өдөр эхэлж 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдөр дуусгахаар гэрээ байгуулсан байна.

Энэхүү гэрээний хэсэг болох гэрээний тусгай нөхцөлд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-д заасан нөхцлийг тусгасан байна.

2.2 Барилгын их засварын зарим ажлыг зураг, төсөвт тусгагдсаны дагуу хийгээгүй байна.

“Хөвсгөл жугнай” ХХК барилгын засварын ажлыг тайлангийн 2.1-д дурьдсан гэрээний хугацаанд дуусгаагүй байна. Уг ажлыг хүлээж авах улсын комиссын актанд: “2014

¹ Аймгийн Засаг даргын тамгын газар
ҮАГ- НАГ/2015/01-НА-ХӨААГ

оны 02 дугаар сарын 06-аас эхэлсэн бөгөөд 2014 оны 02 дугаар сарын 25-ны өдөр дуусгаасан байна” гэж тэмдэглэсэн байна.

“Хөвсгөл жугнай” ХХК гэрээнд заасан хугацаанд ажлаа эхлээгүй болон гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй шалтгааныг тодруулахад:

- Барилгын их засварын ажлын гэрээний биелэлтийг дүгнэсэн хурлын тэмдэглэлд: “Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байсан, ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсон зэргээс гэрээний хугацаа 5 хоногоор хэтэрсэн” гэж тусгасан байна.

Барилгын их засварын гүйцэтгэлийн талаар гэрээ дүгнэсэн хурлын тэмдэглэлд: “Мэргэжлийн хяналтын газар болон Цөмийн энергийн газрын улсын байцаагч нарын хяналтан доор богино хугацаанд чанартай гүйцэтгэсэн. Мөн захиалагч, ашиглагчийн зүгээс гэрээний үүргээ амжилттай биелүүлсэн тул хүлээн авахад татгалзах зүйлгүй” гэж тэмдэглэсэн байна.

Зураг, төсөв зохиогч “Хөвсгөл сууц” ХХК: “Гүйцэтгэгчээр 2 орцны довжоог гантиг чулуугаар өнгөлөх, пандусын талбайг өргөтгөж хашлага хийх, хаяавч бетон нөхөх зэрэг ажлуудыг гүйцэтгүүлэхээр” засварын ажлыг хүлээн авсан байна.

Дээрх шийдвэрүүдийн дагуу захиалагч тал гүйцэтгэгчтэй холбогдох актуудыг үйлдэн их засварын ажлыг хүлээн авсан байна.

Барилгын их засварын ажлыг зураг, төсвийн дагуу хийсэн эсэх болон зураг, төсөв зохиогчийн зүгээс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлсэн эсэхийг шалгахад:

- Зураг, төсөв зохиогчийн зүгээс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй байна. /Зураг, төсөвт тусгагдсан байсан./ Аудитын дүнд дээрх ажлыг гүйцэтгүүлэхээр албан шаардлага хүргүүлж байна.

Зураг 1: Гүйцэтгээгүй ажил /2 орц/



- Барилгын 1 болон 2 дугаар давхарын коридорын плитан шалыг хуулж хиймэл боржин чулуугаар шаллахаар зурагт тусгасан ч плитан шал хийсэн байна.

Зураг 2: Плитан шал



Энэхүү шалны талаар улсын комисс огт дурьдаагүй, “Гэрээний дагуу гүйцэтгэсэн” гэж хүлээн авсан байна.

2.3 Оношлогооны төвийн тоног төхөөрөмжүүдийг бүрэн ашиглаагүй байна.

Хөвсгөл аймагт нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хүрээнд Моносфарм ХХК, Чоноголтрейд ХХК, Си Ай Ти ХХК, Эйч Энд Эйч ХХК, Сетунари ХХК-иуд нийт 21 нэр төрлийн тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1: /мянган төгрөг/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Үнийн дүн	Нийлүүлсэн компани	Ашиглаж буй эсэх
1	Компьютер томограф	Somatom emotion 16	895000.0	Моносфарм трейд	Тийм
2	4D ЭХО аппарат	UGEON60	85998.0	Эйч Энд Эйч	Тийм
3	Шүдний дэлгэмэл рентген аппарат	Papaya	36850.0	Чоноголтрейд	Тийм
4	Авторефрактометр	CRK-7000	8690.0	Чоноголтрейд	Тийм
5	Хялар тодорхойлох багажны иж бүрдэл	Triallenslensset 226pcs	550.0	Чоноголтрейд	Тийм
6	Харааны талбай хэмжигч багаж	AP-5000C	17600.0	Чоноголтрейд	Үгүй
7	Нүдний даралт хэмжигч	HT-5000	2750.0	Чоноголтрейд	Тийм
8	Засварын ламп /биомикроскоп/	Slitlamp YZ5Xi	2640.0	Чоноголтрейд	Тийм
9	Диоприметр	TL-100	2750.0	Чоноголтрейд	Тийм
10	Чихний сонсгол шалгах автомат аппарат	Audiometer	6600.0	Чоноголтрейд	Тийм
11	Чихний сонсгол бичих кабинет	33660	7700.0	Чоноголтрейд	Тийм
12	Чих, хамар хоолойн эмчилгээ оношлогооны ширээ	INU-5000	21120.0	Чоноголтрейд	Тийм
13	Ходоодны видео дурангийн иж бүрдэл	FujinonEG	201675.0	Си Ай Ти	Тийм
14	Урологийн видео дурангийн иж бүрдэл	FujinonEY-470SB	133860.0	Си Ай Ти	Үгүй
15	Дурангийн угаагч, ариутгагчийн хамт	CYW-100	52325.0	Си Ай Ти	Тийм
16	Биохимийн бүрэн автомат аппарат	Cobas c311	75000.0	Сетунари	Тийм
17	Шээсний аппарат дагалдах хэрэгсэл	UriSet2	50000.0	Сетунари	Тийм
18	Гематологийн аппарат	PentraES60	40000.0	Сетунари	Тийм
19	Цус бүлэгнэлтийн аппарат	Sta compact	40000.0	Сетунари	Тийм
20	Илиза уншигч	Cobas c411	75000.0	Сетунари	Тийм
21	Тархины доплер	Delica9UA	60000.0	Сетунари	Тийм

Хүснэгтэд үзүүлсэн тоног төхөөрөмжүүдийг аймгийн ЗДТГ-ын НХХ, ЭМГ, НЭ-ийн удирдлага, албан хаагчид орсон комисс хүлээн авч акт үйлдсэн байна.

Эдгээр тоног төхөөрөмжүүд болон барилгын засварын ажлыг аймгийн НЭ нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Тоног төхөөрөмжүүдийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байгаа эсэхийг шалгахад:

- Аймгийн НЭ-ийн эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн жилийн төсвийн хуваарийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 2: /мянган төгрөг/

№	Зардал	2014 он		2015 он
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө
1	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	934037,8	962050,9	943117,0
2	Үүнээс: Урвалж, оношлуур	90000,0	225805,3	331000,0

Аймгийн НЭ оношлогооны төвийн тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай урвалж, оношлуурын жилийн хэрэгцээг тооцоолоход: 673544,2 мянган төгрөгийн урвалж, оношлуур шаардлагатай гэж гаргасан байна. /Хавсралт 1-ээс харна уу./

Дээрх байдлаас харахад: Тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад шаардлагатай урвалж, оношлуурыг авахад батлагдсан төсөв нь хүрэлцэхгүй байна. Энэ нь дараах тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах боломжгүй болгож байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3: /мянган төгрөг/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Үнийн дүн
1	Биохимийн бүрэн автомат аппарат	Cobas c311	75000.0
2	Шээсний аппарат дагалдах хэрэгсэл	UriSet2	50000.0
3	Гематологийн аппарат	PentraES60	40000.0
4	Цус бүлэгнэлтийн аппарат	Sta compact	40000.0
5	Илиза уншигч	Cobas c411	75000.0
	Нийт дүн		280000.0

Хүснэгтэд үзүүлсэн тоног төхөөрөмжийг зургаар харуулбал:

Зураг 3: Урвалж, оношлуур хангалтгүй байгаа тоног төхөөрөмж



Биохимийн бүрэн автомат аппарат



Шээсний аппарат



Цус бүлэгнэлтийн аппарат



Илиза уншигч

Төсөв хүрэлцэхгүйн улмаас хуучин ашиглаж байсан хагас автомат тоног төхөөрөмжүүдийг */урвалж, оношлуур нь хямд үнэтэй/* давхар ажиллуулан дээрх шинжилгээнүүдийг хийж байна.

Хуучин болон шинэ тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг харьцуулан үзүүлбэл:

Хүснэгт 4:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	
		Шинэ	Хуучин
1	Биохимийн аппарат	Цагт 400 шинжилгээг үзэх хүчин чадалтай. 1 цагт бүх хүний шинжилгээг /300 үзүүлэлтээр/ зэрэг хийнэ.	1 хүний шинжилгээний 300 үзүүлэлтийг 2 минутад хийдэг ба бүх хүний шинжилгээг цувруулан хийнэ.
2	Шээсний аппарат	Цагт 250 шинжилгээ хийнэ. /18 үзүүлэлтээр/	11 үзүүлэлтийг 1 цагт хийнэ.
3	Цус бүлэгнэлтийн аппарат	Цагт 45 шинжилгээ хийнэ, нэг дор 96 сорьц, 45 урвалж байрлуулах боломжтой	
4	Илиза уншигч	Цагт 88 шинжилгээ хийнэ. 30 минутад бүх үзүүлэлтийг уншина.	1 хүний шинжилгээг 10-20 үзүүлэлтээр 3-4 цагт хийнэ.
	Тайлбар	Бүрэн автомат аппарат нь гар ажиллагаа шаардахгүй /гар ажиллагааны үед гардаг алдаанууд гарахгүй/, чанарын хяналт бүрэн хийгддэг, цаг хугацаа хэмнэдэг, олон шинжилгээг зэрэг хийх зэрэг давуу талтай.	

Хүснэгтээс харахад: Бүрэн автомат аппаратыг ашигласнаар оношлогоо сайжирч, эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх боломжтой болсон байна.

- Оношлогооны тоног төхөөрөмжийг ажиллуулж байгаа боловсон хүчний талаар авч үзвэл:

Хүснэгт 5:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоног төхөөрөмжийг ажиллуулж буй сургалтад хамрагдсан ажилтан	Тайлбар, тодруулга
1	Компьютер томограф	Их эмч Ч.Болдбаатар, техникч Ц.Энх-Учрал, инженер Б.Бүдрагчаа нар Дорноговь аймагт 3 хоногийн сургалтанд суусан. Эмч Ч.Болдбаатар компьютер томографийн эмчийн дээшлүүлэх 2 сарын сургалтанд хамрагдсан.	Техникч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийг сургалтанд хамруулах шаардлагатай байгаа.
2	4D ЭХО аппарат	Их эмч Д.Энхтайван 3 сарын сургалтанд хамрагдсан. БНСУ-д эмч Ц.Эрдэнэболор сургалтанд хамрагдсан.	2015 оны 4 сард 1 эмч төгсөж ирнэ.
3	Шүдний дэлгэмэл рентген аппарат	Их эмч Ш.Оюунчимэг, сувилагч Б.Саранчимэг нар 2 сарын сургалтанд хамрагдсан.	Аппаратыг ажиллуулах нөөц мэргэжилтэн бэлтгэх шаардлагатай.
4	Аutoreфрактометр	Их эмч Э.Ганхуяг, Л.Эрдэнэцэцэг нар ажиллаж байгаа. Сувилагч Л.Энх-Амгалан 1 сарын дээшлүүлэх сургалтанд хамрагдан ажиллаж байна.	Нүдний их эмчийг 2015 оны 10-р сараас 3 жилийн хугацаатай, 1 эмч 1 сувилагчийг шинээр бэлдэж сургахаар Эрүүл мэндийн яаманд санал хүргүүлсэн.
5	Хялар тодорхойлох багажны иж бүрдэл		
6	Харааны талбай хэмжигч багаж		
7	Нүдний даралт хэмжигч		
8	Засварын ламп /биомикроскоп/		
9	Диоприметр	Их эмч Ж.Отгон 2 сарын хугацаатай 1-р эмнэлэг, ЭНЭШТ, “ЭМЖЖ” эмнэлгүүдэд сургалтанд суусан.	2015 оны 10-р сард 1 сувилагчийг шинээр бэлтгэнэ.
10	Чихний сонсгол шалгах автомат аппарат		
11	Чихний сонсгол бичих кабинет		
12	Чих, хамар хоолойн эмчилгээ оношлогооны ширээ	Их эмч Ч.Болдбаатар ажиллаж байгаа. Сувилагч Л.Сувд-Эрдэнэ 1 сарын хугацаатай Сонгдо эмнэлэгт сургалтанд хамрагдсан.	
13	Ходоодны видео дурангийн иж бүрдэл		
14	Урологийн видео дурангийн иж бүрдэл	Их эмч Г.Оюунжаргал 6 сарын хугацаатай суралцаж байгаа.	2015 оны 04 сард төгсөнө.
15	Дурангийн угаагч, ариутгагчийн хамт	Их эмч Ч.Болдбаатар, сувилагч Л.Сувд-Эрдэнэ нар ажиллаж байгаа.	
16	Биохимийн бүрэн автомат аппарат	Лаборант н.Гүнсэн 1 сар сургалтанд суусан.	Эмч мэргэжилтнүүд ажлын байрны сургалтанд хамрагдсан. Эмч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийг сургалтанд хамруулах
17	Шээсний аппарат дагалдах хэрэгсэл		
18	Гематологийн аппарат		
19	Цус бүлэгнэлтийн	Их эмч н.Анхтуяа, лаборант	

	аппарат	н.Ундармаа 1 сар Сетунарид сургалтанд суусан.	шаардлагатай байгаа.
20	Илиза уншигч		
21	Тархины доплер	Эмч Ч.Батхишиг 5 сар сургалтанд хамрагдсан.	2015 оны 10-р сард 1 эмчийг шинээр бэлтгэнэ

Хүснэгтээс харахад: Тоног, төхөөрөмж дээр ажиллах эмч, мэргэжилтнийг сургалтанд хамруулсан байгаа ч нөөц эмч, мэргэжилтэн хангалтгүй байна.

Аймгийн НЭ-ээс Эрүүл мэндийн хөгжлийн төвд тоног төхөөрөмжийг ажиллуулах эмнэлгийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах эмч, мэргэжилтний судалгааг хүргүүлсний дагуу хүснэгт №5-д үзүүлсэн эмч, мэргэжилтнүүд сургалтанд хамрагдсан байна.

- Оношлогооны төвийн тоног төхөөрөмжүүдээс дараах тоног төхөөрөмж ашиглалтгүй байна. Үүнд:

Харааны талбай хэмжигч багаж: Уг тоног төхөөрөмжийг байрлуулах өрөөг шийдвэрлээгүйгээс ашиглалтгүй байна.

Зураг 4: Харааны талбай хэмжигч багаж



Урологийн видео дурангийн иж бүрдэл: Уг тоног төхөөрөмжийг ажиллуулах эмч нь бэлтгэгдэж байгаа тул ашиглалтгүй байна.

Зураг 5: Урологийн видео дурангийн иж бүрдэл



- Аймгийн НЭ-ээс дараах тоног төхөөрөмжийг “Хүчин чадал муутай, бүрэн хүчин чадлаар нь ашиглахад нэмэлт програм суулгах шаардлагатай болон өөр тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн” гэсэн тайлбар өгсөн. Үүнд:

Тархины доплер: “Уг тоног төхөөрөмжийн датчикын хүчин чадал нь муу, Герман улсынх биш Хятад улсын чанар муутай нь нийлүүлэгдсэн” гэсэн тайлбар өгсөн.

Зураг 6: Тархины доплер



4D ЭХО аппарат: Аймгийн НЭ-т нийлүүлэгдсэн уг аппарат нь 2D бөгөөд 4D болгон ажиллуулахын тулд дахин програм суулгах шаардлагатай байна.

Зураг 7: ЭХО аппарат



Хялар тодорхойлох багажны иж бүрдэл: Аймгийн НЭ-ээс “Уг тоног төхөөрөмж нь хялар тодорхойлдог бус шилний иж бүрдэл” гэсэн тайлбар өгсөн.

Зураг 8: Шилний иж бүрдэл



Нэгдсэн оношлогооны төвийн тоног төхөөрөмжүүдэд дээрх хүндрэл бэрхшээл, дутагдал байгаа хэдий ч орон нутаг дахь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэвшил гарсан байна. Өөрөөр хэлбэл оношлогооны чадамж сайжирсан байна.

Оношлогооны чадамж сайжрахын хирээр 3 дахь шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд иргэдийг илгээх нь ихэссэн байна. 3 дахь шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд 13А маягтаар илгээсэн иргэдийн тоог *“Оношлогооны төв болсон оныг өмнөх онтой нь харьцуулан”* харуулбал:


Хүснэгт 6:

		2014	2013
1	13А маягтаар илгээсэн иргэд	1471	1130

Оношлогооны тоног төхөөрөмжүүдийг ашиглаж эхэлснээр эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гарч буй үр дүнг дурьдвал:

- Компьютер томограф: Толгой, нүд, чихний хөхөнцөр, хамар дайврын хөндий, хүзүү, сээр, нуруу, бүсэлхий, умайн дайвар эрхтэн, түрүү булчирхай зэрэг эрхтэн тогтолцооны зураг авч оношыг эрт илрүүлж, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмч нарын хагалгааны багийг дуудах, 3 дахь шатлалын эмнэлэгт илгээх, зургийг 3 дахь шатлалын эмнэлэгт илгээн зөвлөгөө авч шийдвэрлэх зэрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Зураг 9: Компьютер томограф



- Шүдний дэлгэмэл рентген аппарат: Бодит үзлэг, рентген зураг хоёрыг харьцуулж онош тавих, шүдний сувгийн эмчилгээг хянах, явцыг харах, эрүүний хугарлыг оношлох, эрүү нүүрний орчин, идээт болон ясны үрэвслийг оношлох, эмчлэхэд үр дүнтэй болсон.

Зураг 10: Шүдний дэлгэмэл рентген аппарат



- Ходоодны видео дурангийн иж бүрдэл: Оношыг эрт тогтоон 2 болон 3 дахь шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлж, эмчлэгдэж байна.

Зураг 11: Ходоодны видео дурангийн иж бүрдэл



Оношлогооны тоног төхөөрөмжүүдийн ашиглалтад орсноос хойш хийсэн нийт үзлэгийн тоо нь 2015 оны 01 дүгээр сарын байдлаар 67700-д хүрсэн байна. /Хавсралт-2/-т үзүүлэв.

Тоног төхөөрөмжийн үйлчилгээний үнийн тухайд: Аймгийн НЭ “Эрүүл мэндийн яамнаас чиглэл өгнө гэсний дагуу эдгээр тоног төхөөрөмжийн үйлчилгээний үнэ, тариф батлагдаагүй ба эрүүл мэндийн даатгалын сангаас авч буй 1 иргэнд ногдох оношлогоо, шинжилгээний хувьсах зардлын хэмжээгээр үйлчилгээ үзүүлж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Барилгын их засварын зураг, төсөвт коридорын шал, гадна довжоог хиймэл боржин чулуугаар өнгөлөхөөр тусгасан ч коридорын шалыг плитагаар өнгөлөн, гадна довжоог өнгөлөөгүй байхад улсын комисс *"Гэрээний үүргээ амжилттай биелүүлсэн"* гэж дүгнэн их засварын ажлыг хүлээн авсан байна.
2. Нэгдсэн оношлогооны төв болсноор 2 дахь шатлалын эмнэлгийн оношлогооны чадамж сайжирсан байна. Оношлогооны чадамж сайжрахын хирээр 3 дахь шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд иргэдийг илгээх нь ихэссэн байна.
3. Нэгдсэн оношлогооны төвийн хүрээнд нийлүүлэгдсэн зарим тоног, төхөөрөмжийг батлагдсан төсөв нь урвалж, оношлуур авахад хүрэлцэхгүй, байрлуулах өрөөг шийдвэрлээгүй, нэр төрөл нь солигдсон зэрэг шалтгаанаар бүрэн хүчин чадлаар нь ашиглаж чадахгүй байна.
4. Оношлогооны тоног төхөөрөмж дээр ажиллах эмч, мэргэжилтнийг сургалтанд хамруулан бэлтгэсэн ч нөөц эмч, мэргэжилтэн хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Дамдинсүрэн, Нэгдсэн эмнэлгийн дарга С.Чагнаадорж нарт:

1. Оношлогооны төвийн тоног, төхөөрөмжүүдийг ажиллуулах эмч, мэргэжилтнийг сургалтанд хамруулж, нөөц бэлтгэхэд анхаарч ажиллах.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга С.Чагнаадорж-д:

1. Харааны талбай хэмжигч тоног төхөөрөмжийг байрлуулах шаардлага хангасан өрөөг шийдвэрлэж, ашиглалтанд оруулах.
2. Чанарын шаардлага хангахгүй байгаа болон нэр төрөл нь солигдон ирсэн тоног, төхөөрөмжийг захиалагч талаас өгсөн техникийн тодорхойлолт, гэрээний нөхцөлтэй тулган асуудлыг шийдвэрлэх.

Холбогдох байгууллагын санал

Тайлангийн төслийг аймгийн ЭМГ, НЭ-ийн удирдлагуудад танилцуулан хэлэлцүүлэг хийж саналыг авсан болно.

Хавсралт 1:

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн оношилгооны төвд шинээр суурилагдсан төнөг төхөөрөмжүүдийн урвалж,
оношлуур болох хэрэглэгдэхүүний судалгаа тооцоо

№	Тоног төхөөрөмж йн нэр	Марк	№	Код	Шаардлагтай урвалж. Оношлуурын нэр	Тун хэмжээ	Гарал үүсэл	хэмжих нэгж	Хэрэглээ				нэгж үнэ	нийт үнэ	
									Өдөр тутам	Сард шаардлагатай тоо хэмжээ		Жилд шаардлагата й тоо хэмжээ			
1	Биохимийн анализатор	Cobasc311	1	03333752190	Alkaline Phosphatase small	200 tests	Roche- Герман	ш	21	438	5256	26.3	27	79900	2157.3
			2	20764957322	AIT	500 tests	Roche- Герман	ш	58	1223	1467 6	29.4	30	181100	5433.0
			4	20766623322	A-Amalyse Pancreatic	200 tests	Roche- Герман	ш	10	218	2616	13.1	14	517500	7245.0
			5	20764949322	ASTL	500 tests	Roche- Герман	ш	21	443	5316	10.6	11	181100	1992.1
			6	03183688122	Albumin BCG	300 tests	Roche- Герман	ш	12	261	3132	10.4	11	104650	1151.2
			7	03146022122	Bilirubin Total DPD	250 tests	Roche- Герман	ш	52	1091	1309 2	52.4	5	105,000	525.0
				5589061190	BIL-D, 350Tests, cobas c,Integra	350 tests	Roche- Герман	ш					2	92,150	184.3
			8	20763128322	Calcium	300 tests	Roche- Герман	ш	4	78	936	3.1	4	97750	391.0
			9	03039773190	Cholesterol	400 tests	Roche- Герман	ш	4	80	960	2.4	3	230000	690.0
			10	4810716190	Creatinine Jaffe	700 tests	Roche- Герман	ш	18	370	4440	6.3	7	184000	1288.0
			11	20767131322	Glucose HK small	200 tests	Roche- Герман	ш	18	364	4368	21.8	22	45100	992.2
			12	3183696122	Iron	200 tests	Roche- Герман	ш	2	37	444	2.2	3	186300	558.9
			13	20737593322	Magnesium	175 tests	Roche- Герман	ш	1	15	180	1.0	2	121300	242.6
			14	3183734190	TP	300 tests	Roche- Герман	ш	15	305	3660	12.2	13	109,250	1420.3
			15	20767107322	Triglycerides	250 tests	Roche- Герман	ш	0.4	8	96	0.4	1	184000	184.0

			16	4460715190	Urea	500 tests	Roche-Герман	ш	0.7	13	156	0.3	1	322000	322.0
			17	20750948322	Antistreptolysin O	100 tests	Roche-Герман	ш	9	273	3276	32.8	33	927,000	30591.0
			18	04628918190	C-reactive Protein High sensitive	300 tests	Roche-Герман	ш	8.4	176	2112	7.0	8	1117800	8942.4
			19	20764574322	Rheumatoid Factor II	100 tests	Roche-Герман	ш	8	168	2016	20.2	21	281750	5916.8
			21	4489357190	NaCl 9% Dil, cobas c	39.2 ml	Roche-Герман	ш					12	59,750	717.0
			22	4489365190	NaCl 9% SI Gen.2, cobas c, Integra	2750 tests	Roche-Герман	ш					2	144,450	288.9
			23	21029398001	Electrode ISE Reference	1 piece	Roche-Герман	ш					2	1680650	3361.3
			24	20763098122	ISE cleaning solution Sys Clean	5x100 ml	Roche-Герман	ш					4	137,500	550.0
			25	20763071122	Sample Cleaner 1, cobas c	12x59.5 ml	Roche-Герман	ш					3	240,200	720.6
			26	11489828216	ISE Compensator 10x1ML (neu)	10x1 ml	Roche-Герман	ш					8	74,850	598.8
			27	11183974216	ISE Standard low 10x3ML	10x3 ml	Roche-Герман	ш					5	41,800	209.0
			28	11183982216	ISE Standard high 10x3ML	10x3 ml	Roche-Герман	ш					5	41,800	209.0
			29	4663632190	Activator for cobas c,Integra,c111	9x12 ml	Roche-Герман	ш					5	293,250	1466.3
			30	4489241190	NaOH-D, cobas c	58.7 ml	Roche-Герман	ш					10	58,750	587.5
			31	4489225190	SMS, cobas c	41.2 ml	Roche-Герман	ш					10	90,500	905.0
			32	20763055122	Ise diluent Gen.2	5x300 ml	Roche-Герман	ш					5	420,000	2100.0
			33	20763063122	ISE Int.Stand. Gen.2, cobas c, Hitachi	5x600ml	Roche-Герман	ш					12	420,000	5040.0
			34	20763071122	ISE Deproteinizer	6x21 ml	Roche-Герман	ш					4	63250	253.0

			35	20738085122	ISE Ref. Electrolyte Solution	1x250 ml	Roche-Герман	ш					4	36800	147.2
			36	20738050122	ISE Solution 1	6x17 ml	Roche-Герман	ш					4	112700	450.8
			37	20738069122	ISE Solution 2	6x9 ml	Roche-Герман	ш					4	131100	524.4
			38	04663632190	Activator	9x12 ml	Roche-Герман	ш					8	293250	2346.0
			39	20754765322	Cleaner	1000 ml	Roche-Герман	ш					12	107525	1290.3
			40	20756350322											
			41	21043862001	Micro cuvettes	20x1000 pieces	Roche-Герман	ш					10	1420443	14204.4
			42	Control, calibration				ш							0.0
			43	10759350190	Calibrator f.a.s	12x3 ml	Roche-Герман	ш					3	281750	845.3
			44	12172623122	Calibrator F.a.s LIPIDS	3x1 ml	Roche-Герман	ш					2	172500	345.0
			45	03555941190	Calibrator F.a.s Pac	3x1 ml	Roche-Герман	ш					2	345000	690.0
			46	11355279216	Calibrator F.a.s Protein	5x1 ml	Roche-Герман	ш					2	1012000	2024.0
			47	12172828322	Preciset RF	5x1 ml	Roche-Герман	ш					2	345000	690.0
			48	03005496122	RF control set	4x1 ml (2 levels)	Roche-Герман	ш					2	488750	977.5
			49	05117003190	Clinchem 1	20x5ml	Roche-Герман	ш					3	1207500	3622.5
			50	05117216190	Clinchem 2	20x5 ml	Roche-Герман	ш					3	1207500	3622.5
			51	21044850001	cobas Integra Waste Container	20 pcs	Roche-Герман	ш					4	941600	3766.4
					дүн				262.5	5561	66732	252.0	370	16937818	122779.6
2	Гематологи йн анализатор	Pentra ES 60	1	0901020	ABX Diluent	20 L	Horiba-Pentra	л	2,8 литр	3 ширхэг /60 л/			36	316,250	11385.0
			2	0903010	ABX CLEANER	1 L	Horiba-Pentra	л	0,2 литр	3ширхэг /3 л /			36	63,250	2277.0
			3	0906013	ABX Lysebio	0,4 L	Horiba-Pentra	л	0,03 л	2 ширхэг			24	126,500	3036.0

			4	0206010	ABX Esonofix	1 L	Horiba-Pentra	л	0,09 л	2 ширхэг			24	253,000	6072.0
			5	0906003	ABX Basolyse	1 L	Horiba-Pentra	л	0,2 литр	3 ширхэг /3 л/			36	241,500	8694.0
			6	2062203	ABX Diffrol	2 N	Horiba-Pentra			0.5			10	332300	3323.0
														166	1,332,800
3	Коагулаграм мийн анализатор	Stacompa ct	1	00667	STA Neoplastine 10	12x10ml	Stago-Франц	л	5	110	1320	1435.0	6	672,000	4032.0
			2	00360	STA Owren koller	24x15 ml	Stago-Франц	л					2	192,000	384.0
			3	00367	STA CaCl2 0.025m	24x15 ml	Stago-Франц	л					2	174,000	348.0
			6	00595	STA PTT5	12x5 ml	Stago-Франц	л	5	110	1320	1435.0	6	777,600	4665.6
			7	00669	STA Thrombin 10	12x10ml	Stago-Франц	л	5	110	1320	1435.0	6	876,000	5256
			8	00674	STA Fibrinogen 5	12x5 ml	Stago-Франц	л	5	110	1320	1435.0	5	1,308,000	6540
			9	00675	STA Uniclibrator	6x1ml	Stago-Франц	л					3	264,000	792
			10	00678	STA System control N+P	12x2x1 ml	Stago-Франц	л					2	1,080,000	2160
			11	00679	STA Coag Control N+P	12x2x1 ml	Stago-Франц	л					27	528,000	14256.0
			12	00724	Deficient IX	6x1 ml	Stago-Франц	л		2	24	26.0	12	456,000	5472.0
			13	00725	Deficient VIII	6x1 ml	Stago-Франц	л		2	24	26.0	2	456,000	912
			14	00973	STA Cleaner solution	6x2.5 ml	Stago-Франц	л					2	378,000	756
			15	00975	STA Desorb U	24x15 ml	Stago-Франц	л					2	324,000	648
			16	38876	Sta cuvette	6*1000	Stago-Франц	л					2	4,266,000	8532
				дүн					20	444	5328	5792.0		11,751,600	54753.6

4	Шээсний анализатор	UriSet2	1		Combur-10-M 100 Str	100 test		ш	496	10912		25100. 0	251	115000	28865.0
			2		Sta cuvette	600test		ш				27000. 0	45	885000	39825.0
				Дүн									296		68690.0
5	Илиза уншигч	Cobas- c411	1	11731360122	T3	200 tests	Roche- Герман	ш	2	40	480	2.4	3	1178250	3534.75
			2	12017709122	T4 Gen.2	200 tests	Roche- Герман	ш	2	40	480	2.4	3	1118500	3355.5
			3	11731459122	TSH	200 tests	Roche- Герман	ш	2	40	480	2.4	3	1231600	3694.8
			4	4481798190	AFP Gen.1.1 Small	100 tests	Roche- Герман	ш	1.4	29	348	3.5	4	587700	2350.8
			5	4854977190	Anti-HAV Gen.2	100 tests	Roche- Герман	ш	1.2	25	300	3.0	2	1201700	2403.4
			6	11820591122	Anti-HAV IgM	100 tests	Roche- Герман	ш	1.2	25	300	3.0	2	1475900	2951.8
			7	3290352190	Anti-HCV	100 tests	Roche- Герман	ш	8.5	178	2136	21.4	22	1665000	36630
			8	4687787190	HBsAG Gen.2	100 tests	Roche- Герман	ш	8.5	178	2136	21.4	22	555000	12210
			9	5390095190	HIV combi PT	100 tests	Roche- Герман	ш	2.7	58	696	7.0	8	913700	7309.6
			10	11732277122	Universal diluent small	2x16 ml	Roche- Герман	ш	1	20			12	114300	1371.6
			11	11361252122	Diluent Hepatitis A	2x15 ml	Roche- Герман	ш	0.1	2			2	171700	343.4
			12	11298500316	ISE cleaning solution Sys Clean	5x100 ml	Roche- Герман	ш					5	198000	990
			13	11930346122	SyS Wash	1x500ml	Roche- Герман	ш					6	40250	241.5
			14	11662988122	Procell	6x380 ml	Roche- Герман	ш					12	160000	1920
			15	11662970122	CleanCell	6x380 ml	Roche- Герман	ш					12	160000	1920
			16	11706802001	Assay cups	60x60 pieces	Roche- Герман	ш					500	307500	153750

17	11706799001	Assay tips	30x120 pieces	Roche-Герман	ш					400	295900	118360
18	3290379190	PreciControl Anti-HCV	16x1.3 ml	Roche-Герман	ш					3	328300	984.9
19	4687876190	PreciControl HBsAg Gen. 2	16x1.3 ml	Roche-Герман	ш					3	364300	1092.9
20	5162645190	PreciControl HIV	6x2.0 ml	Roche-Герман	ш					3	486750	1460.25
21	4855043190	PreciControl Anti-Hav	4x4.0 ml	Roche-Герман	ш					3	505900	1517.7
22	11876368122	PreciControl Anti-Hav igm	4x4.0 ml	Roche-Герман	ш					3	505900	1517.7
23	11731416190	PreciControl Universal Gen. 2	4x3	Roche-Герман	ш					3	135200	405.6
24	4487761190	AFP CS Gen. 2.1	4x1.0 ml	Roche-Герман	ш		0.25			3	196800	590.4
25	11731548122	T3 CS	4x1.0 ml	Roche-Герман	ш					3	196800	590.4
26	12017717122	T4 CS	4x1.0 ml	Roche-Герман	ш					3	196800	590.4
27	4738551190	TSH CS Gen.2	4x1.3 ml	Roche-Герман	ш					3	196,800	590.4
28	11776223322	CA 125 Gen.2	100 tests	Roche-Герман						4	1,045,500	4182
29	3045838122	CA 15-3 II CS	4x1.0 ml	Roche-Герман						8	196,800	1574.4
30	11776258122	CA 72-4 CS	4x1.0 ml	Roche-Герман						8	196,800	1574.4
31	11731629322	CEA Small	100 tests	Roche-Герман						4	817,950	3271.8
32	4784596190	CMV IgG	100 tests	Roche-Герман						4	1,045,500	4182.0
33	11820893122	Myoglobin STAT CS	4x1.0 ml	Roche-Герман						10	196,800	1968.0
34	5094801190	Troponin I STAT CS	4x1.0 ml	Roche-Герман	ш					10	196,800	1968.0
35	5092736190	Troponin T hs STAT CS	4x1.0 ml	Roche-Герман	ш					10	196,800	1968.0

			36	4784618190	CMV IgM	100 tests							4	1,045,500	4182.0
				1177624032 2	CA 125 Gen. 2 CS	4x1.0 ml							2	196,800	393.6
				3045846122	CA 15-3 II CS	4x1.0 ml							2	196,800	393.6
				1177621512 2	CA 19-9 CS	4x1.0 ml							2	196,800	393.6
				1177627412 2	CA 72-4 CS	4x1.0 ml							2	196,800	393.6
				4487761190	AFP CS Gen. 2.1	4x1.0 ml							3	196,800	590.4
				1217822212 2	Myoglobin CS	4x1.0 ml							1	196,800	196.8
				3303071190	HCG STAT CS Gen. 2	4x1.0 ml							1	196,800	196.8
				1173154812 2	T3 CS	4x1.0 ml							2	196,800	393.6
				1201771712 2	T4 CS	4x1.0 ml							2	196,800	393.6
				5202230190	Testosterone CS Gen.2.1	4x1.0 ml							2	196,800	393.6
				5094801190	Troponin I STAT CS	4x1.0 ml							1	196,800	196.8
				1173164532 2	CEA CS Gen. 2	4x1.0 ml							1	196,800	196.8
				3300811190	HCG STAT II	100 tests							1	852,800	852.8
								30.6	635.25	7356	66.4	113 2	22641400	392534.0	
														673544. 2	

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Үзлэгийн тоо
1	Компьютер томограф	Somatom emotion 16	401
2	4D ЭХО аппарат	UGEON60	
3	Шүдний дэлгэмэл рентген аппарат	Papaya	59
4	Авторефрактометр	CRK-7000	7500
5	Хялар тодорхойлох багажны иж бүрдэл /шилний иж бүрдэл/	Triallenslensset 226pcs	8250
6	Харааны талбай хэмжигч багаж	AP-5000C	
7	Нүдний даралт хэмжигч	HT-5000	6100
8	Засварын ламп /биомикроскоп/	Slitlamp YZ5Xi	8000
9	Диоприметр	TL-100	7200
10	Чихний сонсгол шалгах автомат аппарат	Audiometer	2100
11	Чихний сонсгол бичих кабинет	33660	404
12	Чих, хамар хоолойн эмчилгээ оношлогооны ширээ	INU-5000	2100
13	Ходоодны видео дурангийн иж бүрдэл	FujinonEG	531
14	Урологийн видео дурангийн иж бүрдэл	FujinonEY-470SB	
15	Дурангийн угаагч, ариутгагчийн хамт	CYW-100	
16	Биохимийн бүрэн автомат аппарат	Cobas c311	5800 хүнд 23200 шинжилгээ
17	Шээсний аппарат дагалдах хэрэгсэл	UriSet2	
18	Гематологийн аппарат	PentraES60	18000 хүнд 288000 шинжилгээ
19	Цус бүлэгнэлтийн аппарат	Sta compact	470 хүнд 1880 шинжилгээ
20	Илиза уншигч	Cobas c411	470 хүнд 2800 шинжилгээ
21	Тархины доплер	Delica9UA	387

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

Нэг. Албан шаардлага

/сая төгрөг/

№	Сум	Төлбөр хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
		Нэр	Албан тушаал			
1	Аймгийн ЗДТГ	Г.Төмөрбаатар	ЗДТГ-ын дарга	Барилгын их засварын зураг, төсөвт тусгагдсан ажлыг хийгээгүй.	01/15	
		Нийт дүн				

Хоёр. Бусад

/сая төгрөг/

№	Сум	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Хялар тодорхойлох багажны иж бүрдэл нийлүүлэгдэх байсан ч шилний иж бүрдэл нийлүүлэгдсэн.	0,55
2	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	4D ЭХО аппарат бус 2D ЭХО аппарат нийлүүлэгдсэн дахин програм суулгах шаардлагатай.	86,0
	Нийт дүн		86,55

Нийт 86,55 сая төгрөгийн /Наян зургаан сая таван зуун тавин мянган төгрөг/ зөрчил илэрлээ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум
Утас: 70-38 37-93 факс: (976) 70-38 37-93

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.ТӨМӨРБААТАРТ

2015.02.27 № ҮАГ-НАГ/2015/01-ХӨААГ 01/15

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудитортын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу "Монгол улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн аймгуудын нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилт"-д нийцлийн аудит хийхэд: Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Оношзүйн тасгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч "Хөвсгөл жугнай" ХХКомпани нь захиалагчтай /Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатар/ байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 5-д "Гүйцэтгэгч нь Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн Оношзүйн тасгийн их засварын ажлыг батлагдсан зураг, төсөв, даалгаврын дагуу гүйцэтгэх" гэж заасныг зөрчин барилгын 1 болон 2 дугаар давхрын коридор, 2 орцны довжоог хиймэл боржин чулуугаар өнгөлөх, пандусыг өргөсгөж, хашлага хийх зэрэг ажлуудыг гүйцэтгээгүй зөрчил илэрлээ.

Иймд: Монгол улсын "Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн 12-т заасан (...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих...) заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Дээрх зөрчилд дурьдсан ажлыг "Хөвсгөл жугнай" ХХК-иар гүйцэтгүүлэн, хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатарт үүрэг болгон хариуцуулав.
2. Албан шаардлагын биелэлтийг 2015 оны 04 дүгээр сарын 25-ны дотор манайд мэдэгдэхийг аймгийн ЗДТГ-ын дарга Г.Төмөрбаатарт шаардаж байна.

ШААРДЛАГА БИЧСЭН: ШИНЖЭЭЧ



Б.САНДУЙЖАВ